

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2025.10.14

Улаанбаатар хот

Хүний нөөцийн бүрдүүлэлтийн хүрээнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 510 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг, 2025 оны 412 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг тус тус шинэчлэн баталсан. Үүнд:

Захирал 1, Менежер 4, 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын 1 төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төв, аймгийн автотээврийн 21 төв болон Замын-Үүд, Цогтцэций салбар болно. Орон тооны дээд хязгаарыг 769 ажилтан, албан хаагчтай байхаар тогтоосон бөгөөд үйлдвэрийн газрын захирлын 2024 оны А/01, 2025 оны А/55 дугаар тушаалаар үйлдвэрийн газрын ажилтнуудын албан тушаалын ангилал зэрэглэлийг, 2024 оны А/02, 2025 оны А/57, А/81 дугаар тушаалаар Албан хаагчдын үндсэн цалингийн сүлжээг, 2024 оны А/04 дүгээр тушаалаар Алба, төв хэлтсийн ажил, албан тушаалын жагсаалтыг, 2024 оны А/06, А/237, 2025 оны А/82 дугаар тушаалаар аймгийн Автотээврийн төв, салбарын ажил мэргэжлийн жагсаалтыг тус тус шинэчилж батлан, хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

2025 оны 3 дугаар улирлын байдлаар 1 алба, 8 хэлтэс, 4 тасагт 270 ажилтны орон тоо батлагдсанаас 235 ажилтан, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төвд 195 ажилтны орон тоо батлагдсанаас 175 ажилтан, албан хаагч, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбарт нийт 363 ажилтны орон тоо батлагдсанаас 333 ажилтан, нийт 743 ажилтан үйлдвэрийн газарт ажиллаж байна. Үйлдвэрийн газарт нийт 37 гэрээт ажилтан ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны ерөнхий чиглэлийн дараах дүрэм журмуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх зорилгоор захирлын тушаалаар батлан, хүний нөөцийн удирдлагын зохион байгуулалт, албан тушаал, ажлын зохион байгуулалт, албан тушаалд тавигдах шаардлага, хүний нөөцийг бүрдүүлэх, шилж сонгон авах, үр дүнтэй ашиглах, тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн сургалт, хөгжил, ажиллах нөхцөл, баталгаа, гүйцэтгэлийн удирдлагын зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. “Хөдөлмөрийн дотоод журам” - 2022.01.03-ны өдрийн А/01 дүгээр тушаал
2. “Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” - 2015.09.28-ны өдрийн А/209 дүгээр тушаал
3. “Ажилтны сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”- 2015.09.28-ны өдрийн А/208 дугаар тушаал
4. “Ёс зүйн дүрэм” - 2021.09.13-ны өдрийн А/207 дугаар тушаал
5. “Ажилтныг шагнаж урамшуулах түүнийг олгох журам” - 2015.08.31-ний өдрийн А/177 дугаар тушаал
6. “Нэгжийн удирдлага, ажилтны үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам” - 2018.11.07-ны өдрийн А/334 дүгээр тушаал

7. “Мэргэжил, ур чадвар түвшин тогтоох журам” - 2015.10.06-ны өдрийн А/217 дугаар тушаал
8. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх журам” - 2017.09.11-ний өдрийн А/276 дугаар тушаал
9. “Автотээврийн тээврийн үндсэний төвийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам” - 2018.10.08-ны өдрийн А/303 дугаар тушаал,
10. “Автотээврийн тээврийн үндсэний төв ТӨҮГ-ын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг” 2019.12.30-ны өдрийн А/385 дугаар тушаал.

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, үйлдвэрийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ЗСХНХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйлдвэрийн газрын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулан зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Олон жил үр бүтээлтэй, бүтээмжтэй, идэвх санаачилгатай ажилласан 13 ажилтныг мерит зарчмаар албан тушаал дэвшүүлэн ажиллуулж байна.

Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамаарах нууцтай холбоотой баримт бичгийн эргэлт, хадгалах хамгаалах үүргийг хариуцан ажиллаж байна. Үйлдвэрийн газрын төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичгийн бүртгэл, шилжилт, хадгалалт, нууцлалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд аль нэг байгууллагаас төрийн болон албаны нууцад хамаарах 14 албан бичиг ирж тухай бүр холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэсэн.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сар бүрийн 08-ны өдрийн дотор нийтэд ил тод хүргэх шилэн дансны мэдээллийн бүрэлдэхүүн хэсэг хүний нөөцтэй холбогдох мэдээллийг 8 удаа хуулийн хугацаанд мэдээлсэн.

Ажилд шинээр томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн ажилтныг тухай бүр нь үйлдвэрийн газрын цахим дотоод сүлжээний программд бүртгэх болон хасч ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилтыг хийж холбогдох баримт бичиг, мэдээллүүдийг боловсруулан ажиллаж байна. Захиргааны чөлөөтэй, өвчтэй, томилолттой, ээлжийн амралттай ажилтнуудын мэдээллийг тухай бүр цахим дотоод сүлжээний цагийн бүртгэлд бүртгэж ажилласан.

1.7 Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шагнаж урамшуулах, болон сахилга хариуцлагыг дээшлүүлэх асуудлын хүрээнд:

Ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, “Хөдөлмөрийн тухай хууль”, үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу судлан хянаж, удирдлагад танилцуулж тухай бүр шийдвэрлүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 150.000.000 төгрөг баталснаас 138.918.900 төгрөг зарцуулсан, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, эрүүл мэндийг хамгаалах зардалд 580.000.000 төгрөг баталсан. Тухайлбал:

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн газрын ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам”-д нийцүүлэн байр, орон сууц худалдан авах, байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах, эрүүл мэндээ хамгаалах, сургалтын зардалд нь дэмжлэг үзүүлэхийг хүссэн ажилтнуудын өргөдөл хүсэлтийг судлан шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг захирлын 2025.01.20-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар баталсан. Захирлын 2025.06.25-ны өдрийн А/137 дугаар тушаалаар 80 ажилтныг нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт хамруулж, тус бүр 5.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу өргөдөл хүсэлт гаргасан 98 ажилтанд нийт 110.630.000 / нэг зуун арван сая зургаан зуун гучин мянга/ төгрөгийн тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлсэн. Үүнд:

-Гэр бүлд нь шинээр хүүхэд төрсөн 36 ажилтанд 5.400.000 /таван сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийн тэтгэмж олгосон.

Шинээр гэр бүлээ баталуулсан 6 ажилтанд 1.200.000 /нэг сая хоёр зуун/ мянган төгрөгийн тэтгэмж олгогдсон.

-Ар гэрт нь гачигдал тохиолдсон 23 ажилтанд 7.130.000 /долоон сая нэг зуун гучин мянга/ төгрөгийн тусламж олгосон.

- 6 ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгосонтой холбогдуулан 69.600.000 /жаран есөн сая зургаан зуун мянга/ төгрөгийн тэтгэмж, 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл олгосон.

Захирлын зөвлөлийн хуралдаанаар 5 ажилтны эмчилгээний зардалд 22.200.000 /хорин хоёр сая хоёр зуун мянган/ төгрөгийн тусламж, дэмжлэг, нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн.

-22 ахмадад 3.600.000 /гурван сая зургаан зуун мянга/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Тайлант хугацаанд Үйлдвэрийн газрын нийт ахмадуудыг хамруулан цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж 50.400.000 /тавин сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл олгосон.

-Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж үйлдвэрийн газрын нийт албан хаагчдын хүүхдүүдэд Хүүхдийн баярын бэлэгт 59.400.000 /тавин есөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг олгосон.

Монгол Улсад автотээврийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ахмадын хороонд бүртгэлтэй ахмадуудад хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж 25.100.000 /хорин таван сая нэг зуун мянга/ төгрөгийн, Гавьяат тээвэрчин цол хүртсэн Т.Сайдолдад 400,000 /дөрвөн зуун мянга/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл олгосон.

Тус үйлдвэрийн газрын 2025 оны эхний хагас жилийн зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын үр дүнг харгалзан үйлдвэрийн газрын ажилтнуудад ажлын үр дүн, ажилласан хугацаатай нь холбогдуулан нэмэгдэл хөлс, үйлдвэрийн газрын 2024 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын үр дүнгийн дагуу удирдлагын багт 79.800.000 /далан есөн сая найман зуун мянга/ төгрөгийн урамшуулал тус тус олгосон.

-Хууль, хяналтын байгууллагын шийдвэрээр шинжээчээр ажиллаж, тээврийн хэрэгсэлд дүгнэлт гаргасан техникийн хяналтын үзлэгийн төвийн 42 инженерт 4.716.000 /дөрвөн сая долоон зуун арван зургаан мянга/ төгрөгийн нэмэгдэл олгосон.

-“Үйлдвэрийн газрын ажилтны 2025 оны ээлжийн амралтын хуваарь”-ийг 2025 оны өдрийн А/30 дугаар тушаалаар батлан мөрдөж, хуваарийн дагуу ажилтнуудын ээлжийн амралтыг биеэр нь эдлүүлж байна. Тайлант хугацаанд алба, хэлтсийн болон Улаанбаатар хот дахь зорчигч тээврийн 2 төв, техникийн хяналтын үзлэгийн 3 төвийн ээлжийн амралт эдлэх эрх үүссэн нийт 659 ажилтан ээлжийн амралтаа биеэр бүрэн эдэлсэн.

Үйлдвэрийн газрын ажилтнуудын төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч автотээврийн салбарын байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан жилийн судалгааг шинэчлэн гаргаж, 2025 оны өдрийн А/11 дүгээр тушаалаар аймгийн аймгийн Автотээврийн төв, салбарын 324, алба, хэлтэс, төвийн зорчигч тээврийн болон техникийн хяналтын үзлэгийн 5 төвийн 223

ажилтан, нийт 547 ажилтны төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч автотээврийн салбарын байгууллагад ажилласан жилийн нэмэгдлийг 5-25%-иар тогтоон олгож байна.

Монгол Улсын тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 819 жил, Ардын хувьсгалын 104 жил, Монгол Улсад автотээврийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг төрийн одон медаль, Засгийн газрын салбарын шагналаар шагнаж, Үүнд:

- Гавъяат тээвэрчин цол-1
- Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон-21
- Алтан гадас одонгоор -71
- Хөдөлмөрийн хүндэт медалиар -44
- Автотээврийн тэргүүн-17
- Санхүү банкны тэргүүний ажилтан-1
- Онц тээвэрчнээр -2
- Жуух бичиг-19
- Байгууллагын хүндэт өргөмжлөл-27. Өргөмжлөлөөр шагнасан 27 ажилтнд 1.350.000 /нэг сая гурван зуун тавин мянга/ төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.

2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт ажилтны ажлын сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”, Хөдөлмөрийн гэрээний холбогдох зүйл, заалтыг зөрчсөн 39 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулж, 37 ажилтны сахилгын шийтгэлийг хүчингүй болгож, 2 ажилтан сахилгын шийтгэлтэй байна.

Тайлант хугацаанд Үйлдвэрийн газрын ажилтан болон иргэдээс нийт 396 өргөдөл, хүсэлт, албан бичиг ирснээс 304 нь хүний нөөцтэй холбоотой байсан ба үүнээс 296 өргөдөл, хүсэлт, албан бичгийг бүрэн шийдвэрлэж, 8 албан бичиг шийдвэрлэх шатанд хэрэгжиж байна. Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой ирсэн албан бичиг, өргөдөл бүрийг судалж холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тушаалын төслийг боловсруулан удирдлагуудад танилцуулан санал авч, үйлдвэрийн газрын захирлын тушаалаар шийдвэрлэн ажиллаж байна.

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ